

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2018 оны ... дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

**Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

Төмөр замын тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.114 дэх заалтыг тус тус үндэслэн, Эдийн засгийн коридорын хойд коридорыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.4.Хоёр дахь үе шатанд барьж эхлэх “нийт 900 орчим км” гэснийг “нийт 1900 орчим км” гэж өөрчлөх, 3.2.4.4.Хөөт - Бичигт - 200 км, гэсний дараа “3.2.4.5. Зүүнбаян - Ханги - 280 км, 3.2.4.6. Эрдэнэт - Арцсуурь - 780 км” гэж нэмсүгэй.

Гарын үсэг

БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

**ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2016 оны “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан хөтөлбөрийн 2.114-т “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ.” гэж, 2.116-д “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.” гэж тус тус тусгагдсан байна.

Түүнчлэн “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах тухай” Улсын Их Хурлын 2014 оны 64 дүгээр тогтоолоор Эрдэнэт-Арцсуурь (Эрдэнэт-Овоот-Арцсуурь) чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг 1520 мм-ээр барьж байгуулахаар шийдвэрлэсэн.

Манай орны эдийн засагт уул уурхайн салбарын оролцоо өндөр боловч экспортын зах зээлд үнийн ба үнийн бус хүчин зүйлсээс шалтгаалан өрсөлдөх чадвар сайн биш байгаа шалтгаан нь Монгол Улс далайд гарцгүй, дэд бүтэц, тэр дундаа төмөр замын сүлжээ, нэвтрүүлэх чадвар сул байгаатай холбоотой. Иймд төмрийн хүдрийн экспортыг дэмжих, төмөр замын дэд бүтцийн сүлжээг өргөтгөх нэгэн санаачлага болгон Дорноговь аймгийн нутаг дахь Зүүнбаян өртөөнөөс хилийн Ханги боомт хүртэлх шинэ чиглэлийн төмөр замын төслийн урьдчилсан судалгааг хийсэн. Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн тэргүүн нарын хэрэгжүүлэхээр тохиролцсон “Эдийн засгийн коридор”-ын хойд коридор болох Курагино – Кызыл – Цагаантолгой – Арцсуурь – Овоот – Эрдэнэт – Салхит - Замын-Үүд – Эрээн – Улаанцав – Жанчхүү – Бээжин – Тяньжин чиглэлийн төмөр замын төсөл юм.

Монгол Улс тэрбум гаруй тонн төмрийн хүдрийн нөөцтэй бөгөөд үүний 700 орчим сая тонн нь Дархан – Сэлэнгийн бүс нутагт, 200 орчим сая тонн нь УБТЗ-ын төмөр замын сүлжээний трассын ойролцоо (трассаас хоёр тал руугаа 200 км дотор байгаа) нутаг дэвсгэрт оршдог байна. Монгол Улс сүүлийн хоёр жилийн байдлаар жилд ойролцоогоор 6 сая орчим тонн төмрийн хүдэр олборлосноос 4-5 сая тонныг нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бугат дахь төмөрлөг боловсруулах цогцолбор руу илгээж байгаа тул тус улсын, тэр дундаа Бугатын зах зээлээс бүрэн хамааралтай байгаа юм. Зах зээлийн байдал, тээвэрлэлтийн нөхцөл сайжирсан тохиолдолд ойрын жилүүдэд 3-6 сая тонны хүчин чадлыг нэмж ажиллагаанд оруулж, нийлбэр дүнгээр 10-15 сая тонн төмрийн хүдрийг жил бүр авах боломжтой гэж Бугат дахь төмөрлөг

боловсруулах цогцолборын удирдлагууд мэдэгдсэнийг Монголын төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбоо илэрхийлсэн.

Зүүнбаян – Ханги чиглэлийн төмөр замаар тээвэрлэгдэх голлох ачаа нь төмрийн хүдэр байх боловч мөн тодорхой хэмжээний бусад түүхий эд, бараа бүтээгдэхүүн тээвэрлэгдэх боломжтой. Тухайлбал, Дорноговь аймгийн ордуудаас (нийт 150 сая орчим тонн батлагдсан нөөцтэй) жилд олборлогдох 2-4 сая тонн коксждог нүүрс, 0.3-0.5 сая тонн зэсийн баяжмал (Цагаансуварга, Эрдэнэт), Бугат руу ОХУ-аас транзитаар тээвэрлэгдэх боломжтой 1-6 сая тонн нефть, 1 сая тонн мод мөн Бугат-Зүүнбаян чиглэлд тээвэрлэх 1-2 сая тонн бараа бүтээгдэхүүн (барилгын материал, металл хийц, нефтийн бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, хүнд машин механизм) байна гэж судалгаа гарсан.

“Эдийн засгийн коридор”-ын хойд коридор болох Арцсуурь-Эрдэнэт чиглэлийн төмөр замын төсөл нь Тува Улсын Кызыл хотоор дамжин баригдах Кызыл-Курагино чиглэлийн төмөр замтай холбогдон Ази-Европыг холбосон транзит тээврийн шинэ коридорыг бий болгох, гурван улсын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд түлхэц болох, Монгол Улсын хойд бүсийг хөгжүүлэх чухал ач холбогдолтойн дээр мөн Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төмөр замын тээврийн сүлжээг ашиглан гуравдагч зах зээлд хүрэх транзит болон бусад ачаа тээврийн хөнгөвчилсөн шинэ замнал /маршрут/-ыг бий болгон далайн боомтуудад гарцтай болно.

Мөн энэ чиглэлийн төмөр зам нь цаашид Оросын Холбооны Улсын Тува улсын Кызылтэй холбогдсоноор Тувагийн 14 тэрбум тоннын таамаг нөөц, 2,5 тэрбум тоннын батлагдсан нөөц бүхий Улуг-Хемийн нүүрсний сав газрын ордуудаас жилдээ 47 сая тонн хүртэлх нүүрсийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх бололцоотой болно. Уг ачаа урсгалыг Монгол Улсын төмөр замаар дамжуулан тээвэрлэснээр төмөр замын нэвтрүүлэх чадварт сөргөөр нөлөөлөхгүй бөгөөд дамжин өнгөрөх тээврээс Монгол Улс тодорхой хэмжээний орлого олох болно.

Зүүнбаян-Ханги, Эрдэнэт-Овоот-Арцсуурь чиглэлийн төмөр замын судалгаа, урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлээс үзэхэд тухайн төмөр замыг барьж байгуулж, ашиглалтад оруулсанаар тээвэрлэх ачааны доод хэмжээ 15 сая тоннд хүрч байгаа тул Зүүнбаян - Ханги, Мандал-Бугат, Арцсуурь-Эрдэнэт чиглэлийн төмөр замын сүлжээ байгуулах ачаа тээврийн үндэслэл байна гэж үзэж байна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 1 заалттай байх бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.4.Хоёр дахь үе шатанд барьж эхлэх “нийт 900 орчим км” гэснийг “нийт 1900 орчим км” гэж өөрчлөх, 3.2.4.4.Хөөт - Бичигт - 200 км, гэсний дараа “ 3.2.4.5. Зүүнбаян - Ханги - 280 км, 3.2.4.6. Эрдэнэт - Арцсуурь - 780 км” гэж нэмэхээр тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төмөр замын салбарын хамтын ажиллагаа эрчимжиж уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт, тээвэрлэлтийн зардал, хугацаа хэмнэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тогтвортой өсөн нэмэгдсэнээр төсвийн орлого тогтворжиж эдийн засагт эерэг үр дагавар үзүүлнэ.

Монголын төмрийн хүдэр олборлогчдын бүтээгдэхүүний өртгийг 4-8 сая ам.доллараар хямдруулах боломжтой болж, ингэснээр бүтээгдэхүүний өртгийн болон цаг хугацааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, борлуулалтын хэмжээг 10 жилийн хугацаанд 4 сая тонноос 10 сая тонн хүртэл нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр тус салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд оролцооны хувь 2%-4% болж, экспортод эзлэх оролцоо 9.8%-22% болж нэмэгдэнэ. Мөн төмрийн хүдрийн нийлүүлэлтийг нэмэгдүүлснээр Гашуунсухайт, боомтоор Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу экспортлох коксжих нүүрсний хэмжээг 1-3 сая тонноор нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

Зүүнбаян-Ханги, Арцсуурь-Эрдэнэт чиглэлийн төмөр зам баригдсанаар Монгол Улс экспортын түүхий эд, бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар цаг хугацаа, өртгийн хувьд улам нэмэгдэх, улмаар эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулах шинэ төмөр замууд бий болох юм.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн болон тогтоолын төслийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн байх бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.

___оооОооо___